БАТЛАВ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
ДАРГА П.ЭНХ-СОЮН

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.04.04 — Говьсүмбэр аймаг

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт: Гүйцэтгэлийн үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт: Хугацаа | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| **Эрх зүйн үндэслэл:**<br>• **Авлигын эсрэг хууль;**<br>• **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;** | | | | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хүүхэлдэйн зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх | Баримтжуулж, дүнг тооцож тайлагнасан байх. | Жилдээ | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хүүхэлдэйн зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд сурталчилсан байна. | ЗХТасаг, Сургалт, сурталчилгаа хариуцсан албан хаагч, ЭБАТ |
| | | 1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулсан байх | Дэмжиж хамтран ажилласан байх,<br>Зохион байгуулж үр дүнг тайлагнасан байх. | | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажилласан байна. | |
| | | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшил 110" мэдээллийн самбар ажиллуулах | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг тухай бүр байршуулсан байх. | | Мэдээллийн булан, самбар тогтмол ажиллуулсан байна. | |
| 2 | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлигын эсрэг сургалтад албан хаагчдыг хамруулах | 2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлсэн байх | Эрсдэлтэй ажлын байр (албан тушаалын тодорхойлолт)-нд ажиллаж байгаа албан хаагчдыг сонгосон байх | Жилдээ | Сургалтын санал, захиалгыг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Сургалт, сурталчилгаа хариуцсан албан хаагч |
| | | 2.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо, тайлан мэдээ гарсан байх. | | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байна. | |
| 3 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх | 3.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж 3.2 Мөрдөгчийн мэдэгдэл 3.3 Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл бусад албан бичгийн мөрөөр оновчтой, үр дүнтэй ажил зохион байгуулсан байх. Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хугацаанд хүргүүлсэн байх | Жилдээ | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдэл албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлсэн байна. | ЗХТасаг, ЭБАТ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх | 4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага, уриа, аянд нэгдсэн байдал<br>4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | Санал санаачлага, уриа, аянд нэгдэн үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулсан байх.<br>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах альваа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх. | Жилдээ | Гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байна. | ЗХТасаг,ЭБАТ |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах | 5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх. | Жилдээ | Татварын үйлчилгээг цахим хэлбэрээр үе шаттай, иргэд, олон нийтэд хүргэсэн байна. | ЗХТасаг, Нягтлан бодогч |
| 6 | Байгууллагын ил тод нээлттэй байдлыг сайжруулах | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээр байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх | Жилдээ | Мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэсэн байна. | |
| **Эрх зүйн үндэслэл:**<br>**• "Авлигын эсрэг үндэсний чуулган"-аас гаргасан зөвлөмж** | | | | | | |
| 7 | Зөвлөмж 2.1. Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, авлигын эрсдэлийн үнэлгээ зэрэг судалгааны үр дүнд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагад чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх, авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах; | 7.1. Авлигад өртөх эрсдэл бүхий ажлын байр /албан тушаал/-ыг тодорхойлох асуумжийг шинэчлэн, судалгааны үндсэн дээр авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах | 1. Асуумжийн дүгнэлт, өмнө оны асуулгын дүнтэй харьцуулалт<br>2. Боловсруулсан зөвлөмж | Жилдээ | Зөвлөмжийг боловсруулсан, зөвлөмжийн дагуу эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байх | ЗХТасаг, ЭБАТ |
| 8 | Зөвлөмж 2.2. Төрийн албаны их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа уг өгөгдөлд суурилан төрийн албан хаагчийн томилгоог хийх. Энэхүү системийг төрийн байгууллагуудын цахим системтэй интеграцжуулахад холбогдох байгууллагууд дэмжпэг үзүүлэн хамтран ажиллах; | 8.1. Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд татварын албаны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, уг өгөгдөлд суурилсан албан хаагчийг томилгоо хийх | Их өгөгдлийн сангийн дагуу мэдээллийг оруулсан байх | Жилдээ | Татварын албанд ажиллаж байгаа төрийн албан хаагч бүрийн мэдээллийг оруулсан байх | ЗХТасаг, Хүний нөөц |
| 9 | Зөвлөмж 2.3. Төрийн албаны хүний нөөцийн аудитыг Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл хамтран хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн хандпага, соёлыг сайжруулах, ёс зүй, сахилга хариуцлагад тавих хяналтыг чангатгах, төрийн албаны шалгалт, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг судлах, ёс зүй, зан үйлийг үнэлэх сэтгэл зүй туршилтыг өргөжүүлэх; | 9.1. Татварын улсын байцаагч, хураагчид Төрийн албаны хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримлах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах | Авлигын эсрэг хууль, тогтоомж, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцсэн байх | Жилдээ | Татварын албаны сургалт хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөнд тусганы дагуу хэрэгжүүлсэн байх | ЗХТасаг, Сургалт, сурталчилгаа хариуцсан албан хаагч |
| | | 9.2 Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагчийг асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн албан хаагчийг Ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрүүлэх | Хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байх | Жилдээ | Зөрчил дутагдлыг хууль тогтоомжийн дагуу бүрэн шийдвэрлэсэн байна. | ЗХТасаг, ЭБАТ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | Зөвлөмж 2.4. Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавьсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх, томилсон этгээдэд хариуцлага тооцох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд онцгойлон анхаарах; | 10.1. Албан тушаалын шаардлага хангаагүй албан хаагчийг чөлөөлөх, албан үүргийг түр орлон гүйцэтгэхээр томилсон албан тушаалд сонгон шалгаруулалт зарлан томилох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх; | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх | Эхний хагас жилд, жилдээ | Сонгон шалгаруулалтаар томилсон, албан тушаалын шаардлага хангаагүй албан хаагчийг чөлөөлсөн байх. | ЗХТасаг, Хүний нөөц |
| 11 | Зөвлөмж 2.6. Төрийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр болон эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор авлига, залилангийн гэмт хэрэг гарахад нөлөөлөхүйц хүчин зүйлсийг арилгах, аудит хийхдээ хөндлөнгийн болон дотоод хяналтын зохистой горимыг сонгон хэрэглэх; | 11.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4-т заасны дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгчийг оролцуулах | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх | Жилдээ | Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хууль тогтоомжийн дагуу 2-с доошгүй төлөөлөгчийг оролцуулсан байх | ЗХТасаг |
| 12 | Зөвлөмж 2.7. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжээс эрхэлж буй аливаа үйлчилгээ, үйл ажиллагаанд хуульд заагаагүй зөвшөөрөл олгодог явдлыг таслан зогсоох, төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тогтолцоог халах; | 12.1. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас хүлээн авч Татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэх | Төрийн байгууллагаас зохих мэдээллийг авсан байх; | Жилдээ | Төрийн байгууллагуудаас авсан мэдээллийг Татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэсэн байх | ТТХТасаг |
| 13 | Зөвлөмж 2.8. Цахим засаглалыг хөгжүүлэх, Е-Монголиа цахим системээр үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ авахад нэн шаардлагатай тоон бичиг үсгийн чадвартай иргэнийг бэлтгэхэд онцгойлон анхаарах, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, иргэд төрөөс үйлчилгээ авдаг жишгээс төр иргэддээ үйлчилгээ санал болгодог хэлбэрт шилжих; | 13.1. Е-Монголиа цахим системд оруулсан татварын 42 үйлчилгээний мэдээллээр хангах, үйчилгээний төрөл, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, сурталчилгаа хийх; | Е-Монголиа цахим системд оруулсан татварын үйлчилгээний мэдээллээр бүрэн хангасан байх | Жилдээ | Татвар төлөгчид татварын үйлчилгээг цахим системээр дамжуулан хүргэсэн байна. | ТТХТасаг, Сургалт сурталчилгаа хариуцсан албан хаагч |
| 14 | Зөвлөмж 2.10. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн иж бүрэн байдлын түвшинг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох, кодлох, шилэн дансны нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх, аудитын явцад олон нийтийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бүрдүүлэх. | 14.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар болон, урсгал төсвөөр хулалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны явц, худалдан авалт, гэрээ гүйцэтгэлийг шилэн дансанд тухай бүр нийтэх, . Сангийн яам, ТӨБЗГ-аас нэгдсэн програм хангамж, зааварыг тухай бүр хэрэгжүүлэх, Татварын албаны хэмжээнд Нягтлан бодох бүртгэл, программд эрэмбэлж ойлгомжтой бүртгэх ажлыг хийх. | Тухайн жилийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээ хуулийн дагуу хийгдсэн байх. Зөрчил дутагдал гаргалгүй ажилласан байх. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх. | жилдээ | Төсвийн иухай, Шилэн дансны тухай, худалдан авах үйл ажилагааны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүртгэл хөтлөлтийн стандарт бүрэн хангасан байна. | ЗХТасаг Няглан бодогч |

*Жич: Гүйцэтгэлийн тайланг зураг, тоон үзүүлэлт зэргээр баримтжуулан хэрэгжилтийг 06 дугаар сарын 6, 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлнэ.*

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ЗАХИРГАА ХУУЛИЙН ТАСАГ: Б.АРИУНГЭРЭЛ